



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/64

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх Талын нар багийн “Эсгэлэнгийн энгийн уурхайн худгийн засварын ажил”-ыг 2,000,000 (хоёр сая) төгрөгөөр иргэн П.Гантөмөртэй шууд гэрээ байгуулсугай.

2. “Эсгэлэнгийн энгийн уурхайн худгийн засварын ажил”-ыг ажлын даалгаврын дагуу чанартай, тухайн худгаас ашиг хүртэгч иргэдийн оролцоонд тулгуурлан хийж гүйцэтгэхийн иргэн (П.Гантөмөр)-т даалгасугай.

3. Иргэн П.Гантөмөртэй шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга (Д.Шинэбаяр) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ